

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 02 ДУГААР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн салбар зөвлөлийн гишүүдээс 2022 оны төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдөр салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулан 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 11 төрлийн 53 заалттай боловсруулан батлуулсан.

2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр хурлын зөвлөлийг хуралдуулж, зөвлөлийн ажиллах журам, жилийн ажлын төлөвлөгөө, СЕХ-ын нөхөн сонгууль явуулах тухай албан бичгийг танилцуулсан бөгөөд аймгийн ИТХ-ын ээлжит хуралдааны тов зарлах саналыг хурлын алжын албанаас танилцуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу Архангай аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт журмын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/143 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, 19 сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, хурлын шийдвэрийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Төрийн албаны зөвлөл, Засгийн газраас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу байгууллагын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг холбогдох журмын дагуу ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж, аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн боловсруулж баталсан.

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг аймгийн ЗДТГ-ын Хурлын танхимд зохион байгуулж 1 дүгээр сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газраас цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ.

Мөн энэ өдөр аймгийн Засаг дарга сум, агентлагийн дарга нартай 2022 оны үр дүнгийн гэрээ, хамтран ажиллах гэрээ байгуулж, 2021 онд амжилттай ажилласан сумд, агентлагуудад Өргөмжлөл гардуулсан бөгөөд аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргал, Засаг дарга М.Батжаргал нар сум, аймгийн удирдлагуудад төр засгийн бодлого, чиглэлийг танилцуулж үүрэг даалгавар өглөө.

Засгийн газрын гишүүний аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний заалтуудыг холбогдох сум, агентлагийн дарга нарын үр дүнгийн гэрээ, хамтран ажиллах гэрээнд тусган өгч, гэрээний хэрэгжилтийг хангах арга хэмжээ авлаа.

**Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд
Татвар төлөлт**

2022 оны 2 дугаар сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 168.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 169.0 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувиар, орон нутгийн төсөвт 1068.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 900 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Цахимаар татвар төлөх талаар видео бичлэг, татварын тайлан хүргүүлэх хугацааг сануулсан, татвар хууль тогтоомжтой холбоотой 12 мэдээ, мэдээллийг

Архангай аймгийн татварын хэлтсийн пэйж хуудсанд 2-3 удаагийн давтамжтайгаар байршуулан, 992 хүн үзэж, 519 хүн шейр хийж, бусдад түгээсэн.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 87922.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3615.0 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдаж, худалдан авах ажиллагааны бэлтгэл ажил хийгдэж байна.

Санхүүгийн хяналт

Архангай аймгийн Багшийн сургуульд хяналт шалгалт, Орон нутгийн өмчит байгууллагуудад гүйцэтгэлийн хяналт хийгдэж тайлагнах шатандаа явж байна. Өргөдөл хүсэлтийн дагуу Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн байдалд хяналт шалгалт хийгдэж байна.

Архангай аймагт үйл ажиллагаа явуулж буй Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2019-2020 оны үйл ажиллагаанд хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр ажил сайжруулах, анхаарах асуудлаар санал боловсруулж, аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн дагуу хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтанд төсвөөс олгосон нөхөн олговор, түүнийг холбогдох хуулийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн эсэх асуудлаар Архангай аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албан газар, сумдын төрийн байгууллагын 2016-2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж эхэллээ.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

Аймгийн хэмжээнд 2022 оны 02 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 8 удаа гарснаас, объектын гал түймэр 4, объектын гал түймрийн зөрчил 1, малын гоц халдварт өвчин 2, хүний гоц халдварт /ковид-19/ өвчин 1 тус тус гарсан байна.

2 дугаар сард цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулах 1 мэдээг ОБЕГ-ын ГШУГ-аас хүлээн авч орон нутгийн УЦУАлбанаас тодотгож 19 сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, цаг уурчид нийт 2180 алба хаагчдад багц мессежээр дамжуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэл өгч, орон нутгийн “АВ”, “Тамир”, телевизээр сэрэмжлүүлгийг урсдаг хэлбэрээр өдөрт 6 удаа, 8 удаагийн давтамжтай нийт 96 удаа иргэдэд нэвтрүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллалаа.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын даргын тушаал, хурлын тэмдэглэл, албан даалгавар, аймгийн Засаг даргын захирамжаар “Гамшгаас хамгаалах өдөр тутмын бэлэн байдлын зэрэг **Шар түвшин**”-д шилжин ажиллаж, Шуурхай штаб 24 цагийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомж баримт бичгийг эрх зүйн үндэслэл болгон Эрдэнэбулган сумын орон сууцны 32 барилга байгууламж хамрагдаж Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, дүрэм, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомж зөрчсөн 36 зөрчил илрүүлж, 28 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар орон сууцнуудын СӨХ-нд үүрэг чиглэл, заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байршилтай худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний барилга байгууламжуудад Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулан ажиллалаа.

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомж баримт бичгийг эрх зүйн үндэслэл болгон Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8 байгууллагын 11 барилга байгууламж хамрагдаж Гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж, дүрэм, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, тогтоомж зөрчсөн 48 зөрчил илрүүлж, 14 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 2, мэдэгдэл 6-г тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ын дагуу хүсэлт гаргасан 3 аж ахуй нэгж байгууллага, иргэдийн барилга байгууламжид Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт зохион байгуулж шалгалтын явцад 11 зөрчил илрүүлж гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 1, албан мэдэгдэл 2 тус тус хүргүүлж илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж холбогдох журмын дагуу ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг олгосон байна.

“АЮУЛГҮЙ ГАЛЛАГАА” аяны хүрээнд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1,2,3,4,5,7 дугаар баг, 18 сумын хэмжээнд гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, пийшин, зуухны аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дагуу эрсдэлийг үнэлж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байна Аюулгүй галлагаа аяны постерыг пэйж хуудсаар ард иргэдэд сурталчилж, орон нутгийн “АВ”, Тамир телевизээр өдөрт 6 удаагийн давтамжтайгаар 5400 минутын сэрэмжлүүлэг шторк, 9 удаагийн ярилцлага мэдээллийг иргэдэд хүргэсэн.

Шинэ Коронавируст Covid-19 цар халдвараас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, цаг үеийн мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 6858 иргэнд хүрч хандалт авсан байна.

2022 оны 1 дүгээр сард аймгийн хэмжээнд 55 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13, хулгайлах гэмт хэрэг 9, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 9, малын хулгайн гэмт хэрэг 10, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 9, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 5, гэмт хэргийн улмаас нас барсан иргэн 1, гэмт хэргийн илрүүлэлт 45.7 хувьтай байна.

Нийт 1773 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 1654 иргэнд 75.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 185.9 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 30.6 хувьтай байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2022 оны 01 дүгээр хурлын тэмдэглэл, Аймгийн Онцгой комиссын даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 04 тоот албан бичиг, Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 03/185 тоот албан бичгийн дагуу удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус шалгалтыг 6 үсчин, 12 хүнсний дэлгүүр, худалдааны төв, “Хасу” нийтийн худалдааны төвүүдэд хийж, халдвар хамгааллын дэглэм, бүтээгдэхүүний

- Өөрчлөлт – 15
Тамганы хяналтын дугаар олгосон – 22 бүртгэл хийсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022.01.28-ны өдрийн А/25 дугаар тушаалаар 2021-2022 оны хичээлийн жилийн хоёрдугаар хагасын хичээлийг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэр-/5/9 хувилбар/-ээр 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлүүлсэн. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд 19025, Сургуулийн өмнөх боловсролд 5824 хүүхэд суралцаж байна.

2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл улсын хэмжээнд эхэлсэн бөгөөд www.eec.mn цахим хуудсаар 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 4 дүгээр сарын 25-ны өдрүүдэд явагдана. Улсын хэмжээнд 33.0 мянга гаруй, Архангай аймагт 985 сурагч 12-р ангийг төгсөнө. Засгийн газрын шийдвэрийн дагуу энэ жилийн төгсөгч нар Монгол хэл бичгийн шалгалтыг заавал өгсөн байх шаардлагатай бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан сүүлийн 2 жилийн хугацаанд уг шалгалтыг зохион байгуулаагүй юм.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан сургуулийн өмнөх боловсролын 43, ерөнхий боловсролын сургуулийн 168 багшид мөнгөн тэтгэмжийг бүрэн олголоо.

"Good School" сургалтын байгууллагатай хамтран 2021-2022 оны хичээлийн жилийн 12-р ангийн сурагчдад ЭЕШ-ын хичээлүүдээр сургалтын үйл ажиллагаа явуулж, ЭЕШ-д бэлдэж байна. Уг сургалтад 876 сурагч 1751 хичээлд хамрагдаж байна.

Сургалтын төлбөрийн 50 хувийг аймгийн Засаг даргын зүгээс шийдвэрлэн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Орчин үеийн мэдээлэл, технологийн дэвшлийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор бага ангийн багш нарын мэдээлэл зүйн мэдлэгийг сайжруулах "Интерактив хичээлийн хэрэглэгдхүүн бэлдэх арга зүй" сургалтыг 2 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулж 145 багш хамрагдлаа. Сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвараа ашиглан хичээлийг үр дүнтэй зохион байгуулах нэг сарын аян зарлан ажиллаж байна.

Соёл урлаг

2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр аймгийн Соёл урлагийн газраас Соёл урлагийн ажилтны анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Энэхүү арга хэмээнд аймгийн Хөгжимт драмын театр, Музей, Нийтийн номын сан, 18 сумын Соёлын төвийн дарга, албан хаагчид оролцсон.

Соёл урлагийн ажилтны анхдугаар зөвлөгөөний үеэр аймгийн Соёл урлагийн газраас "Соёлын бүтээлч сар" аянаа эхлүүлж байгаагаар зарласан бөгөөд аяны хүрээнд соёлын салбарын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулахад голлон анхаарч ажиллахаар төлөвлөсөн байна.

Аймгийн Нийтийн номын сан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед уншлагын танхимын 50 хувийн дүүргэлттэй халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөн танхимын үйлчилгээ хүргэн ажиллаж байна.

Нийтийн уншлагын танхимаар 20 уншигч шинээр бүртгэж, 319 ирэгсэдэд 651 ном, хүүхдийн уншлагын танхимаар 36 уншигч шинээр бүртгэж, 625 ирэгсэдэд 854 ном, гэрээр ном олголтоор 81 ирэгсэдэд 53 ном, 167 сонин олгож тус тус үйлчилсэн байна.

Эрүүл мэнд

Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоотой хамтран "Сүрьеэгийн сорьц тээвэрлэлт, далд халдварын эмчилгээ" сэдэвт сумын Эрүүл мэндийн төвүүдийн эмч нарыг чадавхжуулах цахим сургалтыг 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр зохион

байгуулж, нийт 57 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна.

PCR шинжилгээнд 3896, түргэвчилсэн шинжилгээнд 3688 иргэнийг тус тус хамруулж, 2284 батлагдсан тохиолдлыг илрүүлж, тусгаарлан эмчилгээнд хамруулсан.

Батлагдсан тохиолдлуудын тандалт судалгааг хийж, 3221 хавьтлыг тогтоож, хянасан.

Вакцинжуулалтын 23 цэгт коронавирусийн эсрэг вакцинжуулалтын 1 дүгээр тунд 72, 2 дугаар тунд 44, 3 дугаар тунд 412, 4-р тунд 877 хүнийг хамруулсан.

2 дугаар сарын 28-ны өдөр “Сувилахуйн тусламж үйлчилгээний шинэчлэл-сувилагч мэргэжлийн үнэ цэнэ” сэдэвт хэлэлцүүлгийг 2 шатлалаар зохион байгуулж, саналыг ЭМЯ-д хүргүүлээ.

Нэгдсэн эмнэлгийн 1-р давхарт Эрүүл мэндийг дэмжих төвийн засварын ажил хийгдэж дууссан бөгөөд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар тус төвд ашиглах 28 нэр төрлийн эмчилгээ оношилгооны тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.

Хайрхан, Өндөр-Улаан сумдын Эрүүл мэндийн төвүүд, Эрдэнэбулган сумын Ар-Мөнхжин өрхийн Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийгдсэн.

Биеийн тамир, спорт

2022 оны 02 дугаар сарын 16-наас 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл орон даяар “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг эхлүүлсэн бөгөөд энэхү аяны хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын спорт заал, танхимыг 06:30-07:30 цагийн хооронд үнэ төлбөргүй болгож, иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийг уриалан, аяны үйл ажиллагааг хуваарь гарган зохион байгуулж байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2022 оны 02 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 1058 иргэн бүртгэлтэй байгаагаас 507 эмэгтэй. Шинэ ажлын байр 49 үүнээс байнгын ажлын байр 49 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 49, зуучлал 47 байна. 2 дугаар 21-ний байдлаар ажил хайгчаар шинээр бүртгүүлсэн 38 иргэнийг LMIS программд бүртгэлээ. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 13, бага-41, суурь-144, бүрэн дунд- 639, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 16, тусгай мэргэжлийн дунд- 23, Дипломын бакалаврын-182 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 27 иргэнийг LMIS програмд бүртгэн тодорхойлолт гарган өгч Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2022.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчдад хуулийн шинэчилсэн зүйл заалт болон хөдөлмөрийн дотоод журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/807, А/216 дугаар хамтарсан тушаалаар Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртлэх насны хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний, өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэгдэн батлагдлаа. Тушаал шинэчлэгдсэнээр асаргааны тэтгэмжийн хамрах хүрээг оновчтой тогтоож, асаргааны тэтгэмжид зарцуулах хөрөнгийг үр ашигтай зарцуулах нөхцөлийг бүрдүүлж өгч байна.

2022-2023 онд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэхээр зөвлөгөө өгөх 1, сэргээн засах үйлчилгээг үзүүлэх 2, гэрийн асрамж халамжийн үйлчилгээг үзүүлэхээр 4 иргэн, төрийн бус байгууллага-2, ахмад настны өдрийн үйлчилгээг үзүүлэхээр 3 байгууллага тус тус магадлан итгэмжлэгдсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягыг хөтлөх журам шинэчлэгдсэн бөгөөд энэ хүрээнд ажилгүйдэл болон жирэмсэн амаржсан, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эмнэлгийн хуудсыг 2022 оны 01 сарын 01-ээс эхлэн цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

2022 оны 02 дугаар сард 15400 орчим тэтгэвэр, тэтгэмж авагчдад 7.5 тэрбум төгрөгийг хугацаанд нь шуурхай олгоод байна.

Малчны нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлж өгсөн материал, ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хүрээнд бүрдүүлж жил авсан материал зэргийг үндэслэн дотооддоо хяналт шалгалтыг зохион байгуулж дууслаа.

CALL center үйлчилгээ буюу 7507-9000 дугаараас 2021 оны 12 сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны байдлаар 948 даатгуулагчид утсаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Хүүхдийн элчийг чадавхижуулах сургалтыг цахимаар зохион байгуулж 19 сумын Хүүхдийн элч нар оролцож хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн эрхийн зөрчилд хэрхэн ажиллах тухай санал бодлоо солилцож, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр 2022 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө баталсан байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

2022 онд Архангай аймаг жилийн эцсийн мал тооллогоор 5.5 сая мал тоолуулж малын тоо өмнөх оныхоос 162245 толгой малаар өссөн. Мөн 2.4 сая хээлтэгч мал тооллогдсон бөгөөд энэ хавар бог малын хээлтэгчийн 85 хувь, бод малын хээлтэгчийн 78 хувь төллөхөөр байна.

Энэ онд Улсын аварга малчин 5, аварга саалчин 1, фермер 1, аймгийн аварга малчин 19 сумын 101 малчин, хошой аварга малчин 7 сумын 7 малчин, аймгийн аварга саальчин 9 сумын 11 саальчин, “Алтан төлийн эзэн”-ээр 12 сумын 19 малчин тус тус шалгарсан.

Малын гоц халдварт шүлхий өвчин гарсан 15 сумаас өдөр бүр өвчлөлийн мэдээ авч нэгтгэн Мал эмнэлгийн ерөнхий газар, аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын газарт тогтмол хүргүүлж байна.

Давхардсан тоогоор (Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Ихтамир, Өлзийт, Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат, Булган) 9 сумын 13 эмгэгт дээж буюу 40 эмгэгт материалд Нян судлалын шинжилгээг стандарт (MNS 4386-96, MNS 4390-96, СА3-1) арга зүйн дагуу хийхэд Cl.Perfringenes-4, Rabies-4 нийт-8 халдварт өвчин тодорхойлогдож дээрх өвчнүүдтэй тэмцэх зааврын дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар арга зүйн зөвлөмжийг өгч ажиллалаа.

Газар тариалангийн чиглэлээр:

2022 онд газар тариалангийн үйлдвэрлэл аймгийн хэмжээнд төмс 275 га, хүнсний ногоо 166 га, жимс жимсгэнэ 80 га, малын тэжээл 4100 га, тосны ургамал 600 га талбайд тариалахаар төлөвлөөд байна.

Үр тарианы үйлдвэрлэлийг 7965 га уриншинд, 4283 га гуурсанд, нийт 12248 га талбайд үр тарианы үйлдвэрлэл эрхлэхэд 2082 тн үр шаардлагатайгаас 1144 тн нөөцөлж, 938 тн үр, 122,48 тн шатахуун, 1048 тн бордоо, 1921 литр ургамал хамгааллын бодисын захиалгыг хүргүүлсэн.

Газар тариалан эрхлэгчдэд шаардлагатай 7 ширхэг үрлэгч, 2 ш үр тарианы комбайн, анжис, ачигч, цэвэрлэгч, бул, борной хаман боогч, ангилангийн жатка, 2 ш трактор, 5 ш хадлангийн иж бүрдэл, тракторын дугуй, бусад сэлбэг хэрэгсэл болон 36 иргэний 45 ширхэг 2254 м² зуны хүлэмж, 8 иргэний 576 м² хүлэмжийн гялгар, 82 иргэн, аж ахуйн нэгжийн 84 га талбайд тариалах 168 тн супер элитээс 1, 2-р үеийн үрийн, 6 иргэн мөөг, чихэр өвс, их шүүдэргэнэ, нугын шимтгэлээ, тэхийн шээгийн үр, чацарганы суулгац 6030 ш, үхрийн нүд 2715, гүзээлзгэнэ 30, алим 108, чавга 100, долоогоно 20, өрөл 13, цагаан нүдэн жимсний мод 10, нийт 9026 ширхэг жимс, жимсгэний суулгацын захиалгуудыг ХХААХҮЯам болон ХААДСанд хүргүүлсэн.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-д Архангай аймаг нэгдэж, 2030 оныг хүртэл 20.0 сая модыг тарьж ургуулах ажлын төлөвлөгөө боловсруулж байна. Мод тарих ажлын хүрээнд тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлэхэд анхаарч Ойн нэгж, ойн ангиудын мод үржүүлгийн газуурдын нөхцөл байдалтай танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын чиглэлээр санал солилцлоо.

Ойжуулалт, ойн зурвас байгуулах, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цөлжилт, газрын доройтлыг бууруулахад орон нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон шилмүүст, навчит модны суулгац, материалыг бэлтгэж, мод үржүүлгийн газарт үржүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж эхлээд байна.

Булган сумын Тамирын голын дагуух улиасанд зориудаар тайралт таналт хийж, байнгын мөчир бэлтгэх плантаци байгуулж, хаврын мод үржүүлгийн газарт таригдах Лавар навчит улиас /*Populus laurifolia* Ledeb/ -ны 5000 ширхэг мөчир бэлтгэлээ.

Барилга, дэд бүтэц, газар

Архангай аймагт 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 2 дугаар сард дараах барилгуудад үе шатны хяналт хийсэн. Үүнд:

- ✓ Жаргалант сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэл 80%
- ✓ Хашаат сумын Сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл 90%
- ✓ Чулуут сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 90%
- ✓ Төвшрүүлэх сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30%
- ✓ Чулуут сумын Соёлын төвийн барилг барилгын ажлын гүйцэтгэл 90%
- ✓ Цахир сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 50%
- ✓ Хайрхан сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 30%
- ✓ Өлзийт сумын сургуулийн барилгын өргөтгөлийн гүйцэтгэл 70%
- ✓ Тариат сумын 50 хүүхдийн цэцэрлэг гүйцэтгэл 40%
- ✓ Цэнхэр сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл 20%
- ✓ Эрдэнэбулган сум 2-р цэцэрлэг барилгын ажлын гүйцэтгэл 20%

Зургийн даалгавар боловсруулах ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яам, Барилгын хөгжлийн төв, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хамтарсан ажлын хэсэг Эрдэнэт үйлдвэрээс санхүүжиж байгаа Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын даалгавар боловсруулж, 19 суманд газар дээр нь хэмжилт хийж, нийт 20 зургийн даалгавар боловсруулсан байна. Үүнд:

Булган сумын Халуун усны барилга, Цэцэрлэг сумын ахуйн үйлчилгээний барилгын засвар, Цэцэрлэг сумын сургуулийн уурын зуухны шугам солих ажил, Эрдэнэбулган сумын 6-р багт малын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр, хүнсний ногооны зоорийн барилга, Чулуут сумын хогийн цэгийн менежмент, Цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж, Худалдааны гудамжны инженерийн дэд бүтэц, Эрдэнэбулган сум 6-р багт баригдах 160 хүүхдийн сургуулийн гадна, тохижилт, шугам сүлжээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

